



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 05 сарын 27 өдөр

Дугаар 3/301

Улаанбаатар хот

Н.Энхцэцэгт сахилгын
шийтгэл ногдуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5, 8.4 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 27 дугаар зүйлийн 27.4.3 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1, 37.1.7, 48 дугаар зүйлийн 48.1.3 дахь заалт, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.7 дахь заалт, Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 36/32 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, түүнд гомдол гаргах журам"-ын 3.5.2 дахь хэсэг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2021 оны А/705 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Улсын бүртгэлийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам"-ын 10.1 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:


1.Хяналт шалгалтын газрын төлөвлөгөөт шалгалтаар Нийслэлийн Чингэлтэй дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтсийн хуулийн этгээдийн улсын бүртгэгч Намжилын Энхцэцэг нь Улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрчсөн нь тогтоогдсон тул 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс албан тушаалын цалингийн хэмжээг 3 сарын хугацаагаар 20 хувиар бууруулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2.Өдөр тутмын үйл ажиллагаандаа холбогдох хууль тогтоомжийг мөрдөж, албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилтоо хэрэгжүүлж, үүрэгт ажилдаа хариуцлагатай хандахыг улсын бүртгэгч Н.Энхцэцэгт үүрэг болгосугай.

3.Албан хаагчдад ажлын хариуцлага, дэг журмыг чанд сахин ажиллахыг анхааруулж, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг нийслэл дэх Улсын бүртгэлийн газар /Г.Анхныбаяр/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Г.Цолмон/-т үүрэг болгосугай.

4.Энэ тушаалыг эс зөвшөөрвөл тушаалыг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор төрийн албаны төв байгууллагад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГА



Д.ДЭЛГЭРСАЙХАН

14780000